

2019 оны 11 сарын 21-ны өдрийн  
Удирдах Зөвлөлийн хурлаар батлав.

## МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧДЫН ХОЛБОО ГҮТББ –ЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү журмаар Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо/цаашид МХТХ гэх/-ноос гаргасан дүрмийн дагуу Монгол улсын иргэн, хуулийн этгээд МХТХ-нд гишүүнээр элсэх, гишүүнчлэлийн хураамж төлөх, эдлэх эрх, мэдээлэл солилцох, гишүүнчлэлийг цуцлах, түдгэлзүүлэх асуудлыг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Монгол улсын үндсэн хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооны дүрэм болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмын хүрээнд мөрдөгдөнө.
- 1.3. Энэ журмын нэмэлт өөрчлөлт болон хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг МХТХ-ны Удирдах зөвлөл батална.
- 1.4. МХТХ болон түүний гишүүний хооронд үүсэх гишүүнчлэлтэй холбоотой харилцааг зохицуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий алба нь **МХТХ-ны Гүйцэтгэх захиргаа** байна.

### ХОЁР. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨРӨЛ, ХУРААМЖ

- 2.1 Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооны дүрмийн 5.1-д заасны дагуу МХТХ-ны гишүүнчлэл үндсэн 4 төрөл байна. Үүнд: Жинхэнэ, Суралцагч, Хүндэт, Дэмжигч гишүүн байгууллага.
- 2.2 Гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг МХТХ-ны удирдах зөвлөлөөс жил бүр батална.
- 2.3 Гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг хуанлийн нэг жилээр тооцно.
- 2.4 Гишүүнчлэлийн эрх, шалгуур болон хураамж нь гишүүний төрлөөс шалтгаалан ялгаатай байна. Үүнд:

Гишүүдийн төрөл	Элсэх шалгуур	Гишүүнчлэлийн жилийн хураамж
Жинхэнэ гишүүн	МХТХ-ны эрхэм зорилго, зорилт, зарчим болон дүрмийг хүлээн зөвшөөрсөн, Аяллын хөтөч тайлбарлагчаар ажилладаг 18 нас хүрсэн Монгол Улсын Иргэн	50,000 төгрөг
Суралцагч гишүүн	МХТХ-ны эрхэм зорилго, зорилт, зарчим болон дүрмийг хүлээн зөвшөөрсөн аяллын хөтөч тайлбарлагчаар цаашид ажиллах хүсэлтэй, МХТХ-ны Аяллын хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох үндсэн сургалтыг 85%-с дээш ирцтэй, амжилттай дүүргэсэн, 18 нас хүрсэн Монгол Улсын Иргэн	Суралцсан эхний жилдээ хураамжаас чөлөөлөгдөнө. Цаашдаа жинхэнэ гишүүний адил 50,000 төгрөгний хураамж төлнө.
Хүндэт гишүүн	Монголын аялал жуулчлалын салбар болон МХТХ-ны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан аяллын хөтөч тайлбарлагч хувь хүнийг МХТХ-ны Удирдах зөвлөлөөс санал оруулж МХТХ-ны Бүх гишүүдийн хурлын дийлэнх олонх буюу 2/3-ын шийдвэрээр <b>Хүндэт гишүүнээр</b> элсүүлнэ.	Гишүүнчлэлийн хураамжаас чөлөөлөгдөнө.
Дэмжигч гишүүн байгууллага	МХТХ-ны эрхэм зорилго, зорилт, зарчим болон дүрмийг хүлээн зөвшөөрсөн аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага	Доод хязгаар 300,000. Хандив өгөх боломжтой.

## ГУРАВ. ГИШҮҮНЭЭР БҮРТГЭХ, ЭЛСҮҮЛЭХ

### 3.1. Жинхэнэ гишүүнээр элсүүлэх

3.1.1. МХТХ-ны жинхэнэ гишүүний бүртгэлийн маягтыг [www.mptga.org/membership](http://www.mptga.org/membership) холбоосоор орж монгол хэлээр, кирилл үсгээр бөглөнө.

- 3.1.2. Бүртгүүлэхдээ холбогдох мэдээллийг үнэн зөв өгөх үүрэгтэй бөгөөд цээж зургийг (jpeg өргөтгөлтэй, IMB-ээс бага хэмжээтэй) файл хэлбэрээр хавсаргасан байна.
- 3.1.3. Гишүүний бүртгэл, элсэлттэй холбоотой асуудлыг холбооны Гүйцэтгэх захиргаа хариуцна.
- 3.1.4. Гүйцэтгэх захиргаа нь гишүүний шалгуур үзүүлэлтэнд заасан бичиг баримтын бүрдэлд үндэслэн хуанлийн 14 хоногийн дотор дүгнэлт гаргаж, хүсэлт гаргагчид мэдээлнэ.
- 3.1.5. Гишүүнээр элсүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргагч нь Голомт банкин дахь М.Хөтөч тайлбарлагчдын холбооны 1105114253 дансанд гишүүнчлэлийн нэг жилийн хураамж болох 50,000 төгрөгийг шилжүүлнэ. Гүйлгээний утган дээр хүсэлт гаргагчийн овог нэр, утас, гишүүнчлэлийн хураамж гэж бичнэ.
- 3.1.6. Гишүүнчлэлийн хураамжийг төлснөөс хойш хуанлийн 14 хоногийн дотор МХТХ-ны Гүйцэтгэх захиргаанаас хүсэлт гаргагчтай холбогдож гишүүний үнэмлэхийг олгоно. Үнэмлэхийг Хавсралт 1-д баталсан загвараар хийнэ.

### **3.2. Суралцагч гишүүнээр элсүүлэх**

- 3.2.1. Энэхүү журмын 2.4-р заалтын шалгуурыг хангасан МХТХ-ны **Аяллын хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох үндсэн сургалтыг дүүргэсэн суралцагчид** сайн дурын үндсэн дээр МХТХ-нд шууд элсэнэ. Гишүүний үнэмлэхийг олгоно.
- 3.2.2. Суралцагч гишүүнийг нэг жилийн хугацаанд гишүүнчлэлийн хураамжаас чөлөөлнө.
- 3.2.3. Цаашдаа жинхэнэ гишүүний адил хураамжаа МХТХ-ны Голомт банкин дахь М.Хөтөч тайлбарлагчдын холбооны 1105114253 дансанд төлөн гишүүнчлэлээ сунгуулна.
- 3.2.4. Аяллын хөтөч тайлбарлагчаар ажилладаг Суралцагч гишүүн нь эхний жилдээ жинхэнэ гишүүнтэй ижил эрх эдлэхийг хүсвэл “аяллын хөтөч тайлбарлагчаар ажилладаг” тухайгаа албан ёсоор нотолж, бүртгэлийн маягтыг бөглөн, жинхэнэ гишүүний хураамж төлж эрхээ нэмэгдүүлж болно.

### **3.3. Хүндэт гишүүнээр элсүүлэх**

- 3.3.1. Энэхүү журмын 2.4-т зааснаар зохицуулна.

### **3.4. Дэмжигч гишүүн байгууллагаар элсүүлэх**

- 3.4.1. Аж ахуйн нэгж байгууллага, дэмжигч гишүүнээр элсэх хүсэлтээ энэхүү журмын 3.5.2-т зааснаар бүрдүүлж [info@mptga.org](mailto:info@mptga.org) хаягаар хүсэлтээ илгээнэ.
- 3.4.2. МХТХ байгууллагын хүсэлтийг хуанлийн 14 хоногт багтаан шийдвэрлэж, гишүүнчлэлийн гэрээ хийнэ. /Хавсралт 2/
- 3.4.3. Гишүүнчлэлийн гэрээ хийгдмэгц дэмжигч гишүүний эрх үүснэ.

### **3.5. МХТХ-нд гишүүнээр элсэхэд бүрдүүлэх бичиг баримт**

- 3.5.1. Хувь хүн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
  - [www.mptga.org/membership](http://www.mptga.org/membership) холбоосоор орж бүртгэлийн маягт бөглөнө

- Аяллын хөтөч тайлбарлагчаар ажилладгийг нотолсон байгууллагын тодорхойлолт хавсаргана.
- 1МВ хэмжээтэй, биеийн цээж хэсэг, нүүр тод гарсан зураг
- Гишүүнчлэлийн хураамж төлсөн баримт (Энэхүү журмын 3.1.4, 3.1.5-т заасны дагуу )

### 3.5.2. Байгууллага

- Гишүүнээр элсэх тухай албан хүсэлт
- Байгууллагын аж ахуйн нэгжийн гэрчилгээ
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ /хэрэв байгаа бол/
- Байгууллагын товч танилцуулга
- Байгууллагын лого
- Гишүүнчлэлийн хураамж төлсөн баримт

**3.6.** Гишүүн үнэмлэхээ гээвэл МХТХ-ны Гүйцэтгэх захиргаанд бичгээр хүсэлт гаргаж, зохих торгуулийг төлөөд шинээр авах боломжтой.

**3.7.** Хүсэлт гаргагчийн бичиг баримтын бүрдэл дутуу, хуурамч мэдээлэл агуулсан нь нотлогдвол МХТХ гишүүнд элсүүлэхээс татгалзана.

**3.8.** Бүртгэлд хамрагдаж, гишүүний үнэмлэх авсан эсвэл дэмжигч гишүүний гэрээ байгуулсан гишүүдийг МХТХ-ны эрхэм зорилго, зорилт, зарчим, дүрэм болон энэхүү журмыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

## **ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ, ДАВУУ ТАЛУУД**

4.1. Энэхүү журмын 4.2-т зааснаас бусад Гишүүний бүрэн эрх нь гишүүний үнэмлэхээ гардан авсан мөчөөс эхэлнэ.

4.2. Хамтран ажиллагч байгууллагуудаас хөнгөлөлт эдлэх эрх нь үнэмлэх авснаас хойш хуанлийн 21 хоногийн дараа нээгдэнэ.

4.3. МХТХ-нд гишүүнээр элссэнээр дараах давуу эрхийг эдэлнэ.

МХТХ-ны сургалт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах	МХТХ-нд Сонирхлын бүлэг, клуб байгуулах	МХТХ-ны сургалтыг амжилттай төгссөн суралцагчдын мэдээллийг бусдаас түрүүнд авах	МХТХ-ноос Шагнагч урамшилд тодорхойлуулах	МХТХ-ны вэбсайтын хамраах хуудсанд мэдээлээ байршуулах	МХТХ-ны хамтран ажиллагч байгууллагуудаас хөнгөлөлт эдлэх	МХТХ-ны сургалт, үйл ажиллагаанд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах	Сонгох, сонгогдох	Бүх гишүүдийн хуралд санал өгөх	Бүх гишүүдийн хуралд оролцох	Хууль ёсны эрх алгаа хамгаалуулах	Гишүүний төрөл /Эдлэх эрх
+	+	-	-	+	+	+	-	-	+	+	Суралцагч гишүүн
+	+	-	+	+	+	+	+	+	+	+	Жинхэнэ гишүүн
+	+	-	+	+	+	+	+	+	+	+	Хүндэт гишүүн
+	-	+	+	+	-	+	-	-	-	-	Дэмжигч гишүүн

4.4. МХТХ, түүний хамтран ажиллагч байгууллагуудаас гишүүдийн эдлэх хөнгөлөлтийн хувь хэмжээ болон бусад өөрчлөлтийг Удирдах зөвлөлөөс жил бүр шинэчлэн тогтоох ба энэ тухай мэдээллийг МХТХ-ны [www.mptga.org](http://www.mptga.org) цахим хуудасны хамтрагч байгууллагууд хэсэгт байршуулна.

#### ТАВ. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

- 5.1. Гишүүний маяганд бүртгэсэн хаяг, утас, цахим шуудан болон фэйсбүүк хаягийг мэдээлэл солилцох суваг гэж ойлгоно.
- 5.2. Энэхүү журмын 5.1-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол энэ тухай МХТХ-нд ажлын 5 өдрийн дотор [info@mptga.org](mailto:info@mptga.org) цахим хаягаар мэдэгдэнэ.
- 5.3. МХТХ-ны үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны товыг гишүүнд түгээх ажиллагааг Гүйцэтгэх захиргаа гүйцэтгэнэ.
- 5.4. МХТХ-ны гишүүд нь МХТХ-ны [www.mptga.org](http://www.mptga.org) цахим хуудаст байршуулсан мэдээ, мэдээлэл, дүрэм, журам болон холбогдох бичиг баримтыг МХТХ-ны албан ёсны эх сурвалж гэж үзнэ.

#### ЗУРГАА. ГИШҮҮНЧЛЭЛ ДУУСГАВАР БОЛОХ

### **6.1.Гишүүнчлэлээс чөлөөлөх**

Дор дурдсан нөхцөлд МХТХ-ны гишүүнчлэлээс Удирдах зөвлөлийн шийдвэрээр чөлөөлж, холбогдох бүртгэлийн өөрчлөлтийг Гүйцэтгэх захиргаа ажлын 5 хоногт багтаан хийж, гишүүнд мэдээлнэ. Үүнд:

- 6.1.1. Гишүүнчлэлийн хураамжаа цаг хугацаанд нь төлөөгүй;
- 6.1.2. Гишүүн өөрөө гарах хүсэлтээ бичгээр гаргасан;
- 6.1.3. Нас барсан буюу бусад хүндэтгэх шалтгаанаар;
- 6.1.4. Хуулийн этгээд, эсвэл байгууллага татан буугдсан, дампуурсан

### **6.2.Гишүүнчлэлийг цуцлах**

Гишүүн нь доорх заалтуудаас зөрчсөн тохиолдолд **Бүх гишүүдийн хурлаар нийт саналын эрхийн 3-ны 2-с дээш** саналаар гишүүнчлэлийг цуцална.

- 6.2.1. Холбооны эрхэм зорилго, зорилт, зарчим болон энэхүү дүрэм, түүнд нийцүүлэн гаргасан бусад журмыг зөрчсөн;
- 6.2.2. Холбооны нэр төрд хохирол учруулсан, холбооны сургалтын хөтөлбөр, агуулга, заах аргазүйг бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хуулбарлан тараасан нь баримтаар нотлогдсон;
- 6.2.3. Холбооны гишүүнчлэлийн хөнгөлөлт эдлэх эрхээ бусдад дамжуулсан, өөрийн хэрэглээнээс давуулан ашигласан, мөнгө санхүүгийн болон ёс зүйн ноцтой зөрчил гаргасан
- 6.2.4. Холбооны нэрийн дор хууль бус, өөрт эрх нь олгогдоогүй эрхээр аливаа үйлдэл хийх болон үйл ажиллагаа явуулсан нь баримтаар нотлогдсон;
- 6.2.5. Холбооны гишүүний эрхийг цуцлах тохиолдолд, өөрт нь урьдчилан бичгээр мэдэгдэж энэ асуудлыг хэлэлцэх хуралд биеэр оролцон тайлбар өгөх боломжоор хангана.

### **6.3.Гишүүнчлэлээс түдгэлзүүлэх:**

- 6.3.1. Энэхүү журмын 6.2.1, 6.2.2, 6.2.3, 6.2.4 заалтыг зөрчсөн нь удирдах зөвлөлийн хурлаар тогтоогдсон бол Бүх гишүүдийн хурал хүртэл гишүүний эрхийг түдгэлзүүлнэ.

- 6.4. Холбооны гишүүн нь холбооны гишүүнчлэлээс чөлөөлөгдсөн, гишүүнчлэлийн эрхийг цуцалсан бол гишүүний татвар, хандивыг буцаан олгохгүй.